

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАНИЛЦУУЛГА

Биеийн тамир, спортын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Биеийн тамир, спортын салбар 2003 онд бие даасан хуультай болж, төрийн зохицуулалт, дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж, биеийн тамир, спортоор хичээллэгчдийн хамрах хүрээ, спортын төрөл, хэлбэрүүд нэмэгдэхийн хирээр төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөл сайжруулах зэрэг олон төрлийн харилцааг хуулиар зохицуулах шаардлага бий болсноор 2017 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.

Шинэчлэн батлагдсан хуулиар биеийн тамир, спортын салбарын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулах, иргэдийн сонирхол, хандлага, хэрэгцээнд тулгуурлан өөрийгөө хөгжүүлэх, бие бялдрын мэдлэг, боловсрол олгох, салбарын хүний нөөцийн мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх, тэдгээрийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Мөн спортын холбоодын эрх үүргийг тодорхойлсон бөгөөд төрийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд хуулиар олгогдсон зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлэх, олон улсын жишгийн дагуу спортыг бизнесийн зарчмаар хөгжүүлэх, спортод хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэхэд төрөөс бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгосон. Жишээлбэл: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан 701 төрлийн барааг татвараас чөлөөлснөөр спортод хувийн хэвшлийн оролцоо нэмэгдүүлэн 2019 оны 06 дугаар сараас 2020 оны 04 дүгээр сарын хугацаанд 6 тэрбум төгрөгийн спортын зориулалттай тоног төхөөрөмж, хэрэглэлийг гаалиар оруулж, 375 сая төгрөгийг гаалийн татвараас чөлөөлсөн нь биеийн тамир, спортын тоног төхөөрөмж, хэрэглэлийн хангамж нэмэгдэж байгаагийн илрэл юм.

Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар 2018 оноос үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн, Монгол Улсад зохиогдох тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээнийг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг Спортын мэргэжлийн холбоодод гэрээний дагуу шилжүүлдэг болсон.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд 2020 онд Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын

хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороог байгуулсан, Монгол Улсын тай холбогдон Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн.

Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах тухай хуулиар дараах эрх зүйн харилцаануудыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулах болно. Үүнд:

Биеийн тамир, спортын байгууллага босоо тогтолцоонд шилжиж байгаа учир харьяа байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх, бүтэц орон тоог батлах зохицуулалтыг нэмэлтээр оруулах, асуудал эрхэлсэн сайдын зарим эрхийг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд шилжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагааг аж ахуйн нэгж байгууллагад идэвхжүүлэх үүднээс байгууллага өөрийн санаачилгаар биеийн тамир, спортын нэгж байгуулах, биеийн тамирын арга зүйч ажиллуулах, биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сантай холбоотой харилцаанд өөрчлөлтийг тус тус оруулсан болно.

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.6-д заасан эрхэлсэн сайдын батлах “Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам”-ыг Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 8 дахь заалтыг баримтлан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран 2019 онд хамтарсан тушаалаар баталсан.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд “Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам”-ыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжүүлэхээр тусгасан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь хэсэгт спортын холбоодыг “... мэдээллийн цахим сантай байх”-аар заасан бөгөөд “e-mongolia” төрийн мэдээллийн цахим сан, “Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан”-ийн үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор спортын холбоодын мэдээллийн санг салбарын нэгдсэн цахим сантай холбож, төвлөрүүлэх шаардлага гарч буй тул холбогдох зохицуулалтыг тусгасан.

Салбарын хэмжээний улсын төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг газар зүйн байршил, хүн амын тоотой уялдуулж тооцох, төлөвлөх норм, аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэхэд хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээ байхгүй байгаа тул биеийн тамир, спортын салбарын санхүүжилтийн дэд тогтолцоог боловсронгуй болгоход хүндрэл үүсэж байгаа тул холбогдох зохицуулалтын тусгана.

Түүнчлэн Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдуулан Галт зэвсгийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлнэ.

Дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтийг Биеийн тамир, спортын тухай хуульд тусгаснаар салбарын хэвийн үйл ажиллагааг хангах бөгөөд улсын төсөв нэмэлт ачаалал үүсгэхгүй, биеийн тамир, спортын төрийн байгууллагуудын хэмжээнд бүтэц орон тоо, төсөв зардал нэмэгдэхгүй учир холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны ... өдөр

Улаанбаатар
хот

**НЭГ. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуульд дор дурдсан агуулга бүхий 10 дугаар зүйлийн 10.1.14, 10.1.15, 10.1.16, 10.1.17 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалт нэмсүгэй.

10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт:

“10.1.14. Монгол Улсад зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтыг батлах.”

“10.1.15. аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороо /төрийн захиргааны байгууллага/-ны даргыг томилж, чөлөөлөх.”

“10.1.16. өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээнд оролцуулах үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах эрх олгох журмыг баталж, хэрэгжилтийг хангах.”

“10.1.17. улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангиллыг олон улсын дүрмийн дагуу тогтоох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангах.”

24 дүгээр зүйлийн 24.3 дэх заалт:

24.3. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт зохион байгуулах биеийн тамир, спортын арга хэмжээний суурь зардал, сум, хороодын хүн амын тооноос хамаарч арга хэмжээний давтамж нэмэгдэж норм, иргэдийн бие бялдрын түвшнийг сайжруулахад зориулсан идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамирын үйлчилгээ, спортын амжилтын өрсөлдөх чадварыг сайжруулах спортын сургалт-дасгалжуулалтын үйлчилгээний хувьсах зардлын нормыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.7 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.3.8 хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“10.1.6. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журмыг баталж, хэрэгжилтийг хангах.”

“10.1.7. улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмыг баталж, хэрэгжилтийг хангах;”

“11.3.8. энэ хуулийн 10.1.8-д заасан биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд холбооны бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулсан спортын тэмцээн, наадам, тамирчны амжилт, спортын цол, зэрэг, гишүүнчлэлийн мэдээллийг оруулах”

“13.1.5. биеийн тамир, спортын нэгж байгуулж, биеийн тамирын арга зүйч ажиллуулж болно.”

“15.3. Спортын клубийг магадлан итгэмжлэх журам, шалгуур үзүүлэлт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, спортын клубийг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.”

“18.4. Энэ хуулийн 10.1.7-д заасан журмын дагуу сонгосон спортын төрлийн спортын холбоонд гэрээний дагуу улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь спортын холбоотой Захиргааны ерөнхий хууль, холбогдох журмын дагуу гэрээ байгуулж, санхүүжүүлнэ.”

“20.3.1. тамирчин Олон улсын олимпийн хорооны ивээл доор зохион байгуулагддаг тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадам, болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртвэл энэ хуулийн 6.1.8-д заасан мөнгөн шагнал авах;”

“24.1. Энэ хуулийн 6.1.6 дахь заалт, 17.2, 18.4, 22.1, 26.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

3 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.6, 8.1.8 дахь заалт, 9.4, 9.4.1 дэх хэсэг, 16.1, 19.3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Биеийн тамир, спортын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Галт зэвсгийн тухай хуульд
өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Монгол Улсын Их хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороог байгуулсан.

Үүнтэй холбогдуулан 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороонд шилжүүлж, салбарын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн тул Галт зэвсгийн тухай хуулийн зарим заалтыг өөрчлөн найруулах шаардлага үүссэн болно.

Иймд биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг дагаж Галт зэвсгийн тухай хуулийн зарим заалтыг өөрчлөн найруулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Одоогийн хүчин төгөлдөр хуулиар спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хууль зүйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах эрхтэй байгааг өөрчлөн “спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага”-тай хамтран батлах хуулийн өөрчлөлтийг оруулах саналтай байна.

Дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтийг тусгаснаар салбарын хэвийн үйл ажиллагааг хангах бөгөөд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, харьяа байгууллагын хэмжээнд бүтэц орон тоо, ямар нэгэн төсөв зардал нэмэгдэхгүй учир холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны ... өдөр

Улаанбаатар
хот

**ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.8 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“4.2. Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалтыг хууль зүйн, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батална.”

“10.3. Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батална.”

“11.8. Галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллага олгоно.”

“11.9. Спорт-сургалтын зориулалтаар ашиглах болон энэ хуулийн 16.6-д заасан төвийн буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавих шаардлагыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батална.”

“19.5 Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн спорт-сургалтын зориулалттай галт зэвсэг, сумыг спортын тэмцээнд оролцох, бэлтгэл хийх хэрэгцээнд зориулан улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Биеийн тамир, спортын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын их хурлаас 2017 онд биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж хуулийн “15 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардал” бүлгийн 15.1.8 дахь хэсэгт “Спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийг хандив” тусган баталсан юм.

Энэ спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжлэг үзүүлэхэд төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын ахлах байсан.

Гэвч хуулийн тус заалтыг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулан “Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив” гэж найруулсан байдаг.

Ингэснээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон спортын холбоо, клубийн хоорондын харилцааны дундуур Засгийн газрын тусгай сан “Спортыг дэмжих сан”-г оруулж ирсэн бөгөөд өөрөөр хэлбэр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаас спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгч байгаа хандивт төрийн оролцоог оруулж ирсэн.

Энэ нь биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаанд төсвийн бус санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх гэсэн бодлогын зорилтыг хэрэгжих боломжгүйд хүргэж байна.

Иймээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь хэсэгт “Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийг хандив” гэсний “Спортын дэмжих санд” гэснийг хасах саналтай байгаа бөгөөд бизнесийн байгууллагаас спортын холбоо, клубийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон хандивын хэмжээг нэмэгдүүлэхэд төр татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх нь зүйлтэй гэж үзэж байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны ... өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

15 дугаар зүйлийн 15.1.8 дэх заалт:

“15.1.8. “Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өсгөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив гэсний “Спортын дэмжих санд” гэснийг хасах;

2 дугаар зүйл. Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2019 онд хийсэн “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний IV судалгаа-2019”-ний тайланд хүн амын 21.9 хувь хөдөлгөөний хомсдол бүхий эрсдэлт бүлэгт хамрагддаг, 61 хувь нь биеийн хүч их шаардсан өндөр эрчимтэй хөдөлгөөн хийдэггүй, хүйс хамааралгүй 25 ба түүнээс дээш насны хүн амын Биеийн жингийн индексийн дундаж үзүүлэлт Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн үзүүлэлттэй байна.

“Идэвхтэй дасгал, хөдөлгөөнөөр хичээллэх талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тогтоох үндэсний судалгаа-2019”-ний тайланд идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхгүй байх гол шалтгааныг тодруулахад 2 хүн тутмын 1 нь зав гардаггүй, 11.1 хувь нь спорт, фитнес клубийн үнэ төлбөр өндөр, 5.3 хувь нь идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх дургүй гэсэн байна.

Биеийн тамир, спортын салбар нь дээр судалгаанд үндэслэн иргэдийн өглөө эрт идэвхтэй хөдөлгөөн хийлгэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх дургүй иргэдийн татан оролцуулах арга хэмжээг сум, хороодод зохион байгуулж байгаа ба “спорт, фитнес клубийн үнэ төлбөр өндөр” гэсэн хүн амыг урамшуулахад чиглэсэн магадлан итгэмжлэгдсэн спортын клубт 3 сар тогтмол хичээллэсэн иргэнд сарын 20,000.0 төгрөгийн урамшуулал олгох зохицуулалтыг “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-д тусгасан байсныг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэнд урамшуулал олгох дэд тогтолцоо нь дээр дурдсан судалгаагаар гарч буй сөрөг үзүүлэлтийг арилгахад чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэн гурвын түншлэлд тулгуурласан, төрөөс хувийн хэвшил, иргэдийг дэмжсэн бодлогын арга хэмжээ байсан бөгөөд үр дүнд нь хувийн хэвшлээс иргэд үзүүлж буй үйлчилгээний чанар сайжирч, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, иргэн тогтмол идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэж хөдөлгөөний хомсдол, илүүдэл жин болон таргалалтаа ангижрах боломжтой.

Мөн тус арга хэмжээний хүрээнд орон нутгийн спортын клубүүдэд стандартын шаардлага хангаж магадлан итгэмжлэгдэх санаачлаг нэмэгдсэн бөгөөд улсын хэмжээнд магадлан итгэмжлэл авсан 16 спортын клубийн 68.7 хувь нь Улаанбаатар хот, 31.2 хувь нь орон нутгийн спортын клуб байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэнд “Спортыг дэмжих сан”-аас урамшуулал олгох зохицуулалтыг нэмэлтээр оруулах асуудлыг тусгасан бөгөөд бусад харилцааг Засгийн газрын

тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасан “Спортыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-аар зохицуулна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны ... өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дахь хэсэгт дор дурдсанаар нэмэлт оруулсугай.

14 дугаар зүйлийн 14.1 дэх заалт:

“14.1 “Спортыг дэмжих сан нь нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх” гэсний дараа “магадлан итгэмжлэгдсэн спортын клубт тогтмол хичээллэсэн иргэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж нэмэлт оруулах ;

2 дугаар зүйл. Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---